



ХОРИХ АНГИ, АЛБА, НЭГЖИЙН  
ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, 13/1, Утас: 26-63-09, Факс: 32-99-33  
E-mail: info@cd.gov.mn, http://www.cd.gov.mn/

2013.07.18 № 01/2814

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Журам мөрдүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд "Архивын тухай", "Төрийн албан ёсны хэлний тухай" хууль, "Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар", "Баримт бичгийн стандарт", "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар", "Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар" зэрэг төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд мөрдлөг болгох хууль тогтоомжуудыг нэг мөр бүрэн хэрэгжүүлэх талаар ШШГЕГ-аас онцгойлон анхаарч, зохих хөрөнгө, зардал гарган хорих анги, албадын удирдлага болон архив, бичиг хэргийн ажилтнуудад мэргэжлийн хүмүүсээр хичээл сургалт зохион байгуулж, гарын авлага, лавлах материалаар ханган, тодорхой үүрэг чиглэлийг байнга өгч ирсэн билээ.

Гэтэл зарим хорих анги, албадад дээрх хууль тогтоомж, заавар, журмыг чанд мөрдөхгүй, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сулруулах, алба хаагчид өөрт олгогдоогүй эрх эдлэх, баримт бичгийн стандартыг зөрчих, үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай бичих зэрэг дутагдал амь бөхтэй оршсоор байна.

Хорих анги, албадын дэд дарга нар Хууль зүйн сайдад шууд хандсан албан бичигт гарын үсэг зурж ирүүлэх, дээд газрын хариутай бичгийн огноо, дугаарыг хэвлэмэл хуудсанд заасан тэмдэглэгээний хэсэгт бүрэн, жигд бичихгүй байх, харьяаллаар шилжүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр хэрхэн шалгаж тодруулсан тухай холбогдох танилцуулгыг тодорхой, дэлгэрэнгүй бичдэггүй, хэт ерөнхийлөн тоймлох зэрэг ноцтой зөрчил, дутагдал гаргасан талаар Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын албан бичигт дурджээ.


Иймд дээрх байдалд дарга нар онцгой анхаарч, албан хэрэг хөтлөлтийн журам, зааврыг чанд мөрдөн, түүний хэрэгжилтэд тавих дотоод хяналт, шаардлагаа эрс өндөржүүлэн, анги, албадын дарга нар Хууль зүйн сайдад, ялангуяа дэд дарга нар Хууль зүйн сайд, ШШГЕГ-ын даргад шууд хандсан албан бичигт гарын үсэг зурдаг явдлыг нэн даруй таслан зогсоохыг хатуу мэдэгдье. Харин албан ёсны амралт, чөлөөтэй байгаа дарга нарын хувьд дэд дарга нар тухайн даргадаа албан ёсоор илтгэн танилцуулж ШШГЕГ-т уламжлан шийдвэрлэж хэвших нь зүйтэй.

Цаашид дээрх зөрчил гаргасан удирдах ажилтанд зохих хариуцлага тооцох болохыг анхааруулья.

Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын 2013 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 712740 дүгээр албан бичгийг хавсарган хүргүүлэв.

Хавсралт 01 хуудастай

ДАРГА, ХУРАНДАА



Д.ЯДАМДОРЖ